

# ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО



## Зорилго

“Оюу толгой” компани нь осол аюулгүй бөгөөд тогтвортой ажиллах дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлж, дэмжихэд чиглэсэн үндэсний худалдан авалтын бодлогыг мөрдөн ажилладаг.

Одоогийн болоод ирээдүйн шинэ ханган нийлүүлэгчдийн чадавхыг хөгжүүлэх хүчин чармайлтыг “Оюу толгой” компани идэвхтэй дэмждэг бөгөөд импортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээг дотоодын эх үүсвэрээс хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор компаниудтай түншилж ажиллана.

“Оюу толгой” ХХК-ийн үйл ажиллагааны хэсэг болон Гүний уурхайн төслийн ханган нийлүүлэгчдийг дэмжин хөгжүүлэхэд баримтлах ерөнхий зарчмыг энэхүү бодлогод тодорхойлсон болно. Энэхүү бодлогын баримт бичиг нь Хөрөнгө оруулалтын гэрээ, Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ, Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг амлалттай нийцэж байгаа болно.

## Бодлого

Өмнөговь аймагт үйлчилгээний чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн худалдан авалтын боломжийг нэмэгдүүлэх нь “Оюу толгой” ХХК-ийн нэн тэргүүний зорилт бөгөөд компани ханган нийлүүлэлтийн сүлжээний зардлыг багасгаж, бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна.

**Өмнөговийн ханган нийлүүлэгч<sup>1</sup>** нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, техникийн шаардлагуудыг хангаж, өрсөлдөхүйц үнэ санал болгосон нөхцөлд тэдэнд үндэсний болон гадаадын ханган нийлүүлэгчдээс давуу эрх олгож сонгоно.

**Үндэсний ханган нийлүүлэгч<sup>2</sup>**-дийг боломж бүрдмэгц Өмнөговийн ханган нийлүүлэгч болохыг дэмжин ажиллах бөгөөд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, техникийн шаардлагуудыг хангаж, өрсөлдөхүйц үнэ санал болгосон нөхцөлд тэдэнд гадаадын ханган нийлүүлэгчдээс давуу эрх олгож сонгоно.

“Оюу толгой” компани нь түүний осол аюулгүй бөгөөд тогтвортой дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх зорилтыг ойлгон дэмжих **гадаадын ханган нийлүүлэгч<sup>3-5</sup>**-тэй хамтарч ажиллахыг илүүд үзнэ. Гадаадын ханган нийлүүлэгчид нь боломж бүрдмэгц Өмнөговийн болон үндэсний ханган нийлүүлэгч болох, эсвэл Өмнөговийн болон үндэсний ханган нийлүүлэгчдэд хөрөнгө оруулах, тэдэнтэй түншлэх замаар дотоодын тогтвортой оролцоог хангаж ажиллахыг дэмжинэ. Техникийн шаардлага хангасан, мөн Өмнөговийн болон үндэсний ханган нийлүүлэгчдээс өрсөлдөхүйц үнэ санал болгоогүй нөхцөлд 1-р ангилалд багтаж буй гадаадын ханган нийлүүлэгчид 2-р ангиллын гадаадын ханган нийлүүлэгчээс (үүний нэгэн адил 2-р ангилалд багтаж буй ханган нийлүүлэгч 3-р ангиллын гадаадын ханган нийлүүлэгчээс давуу эрхтэй байна) давуу эрх олгож сонгоно.

- 1. Өмнөговийн ханган нийлүүлэгч** гэж доорх шаардлагыг хангасан үндэсний ханган нийлүүлэгчийг хэлнэ. Үүнд:
  - Өмнөговь аймагт бүртгэлтэй байх,
  - o Өмнөговь аймагт бараа үйлдвэрлэдэг, нийлүүлдэг, эсвэл үйлчилгээ үзүүлдэг байх,
  - o Нийт үндсэн ажилтны 75-аас дээш хувь нь Өмнөговь аймагт амьдарч, ажилладаг Монгол Улсын иргэн байх,
  - o “Оюу толгой” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж буй тухайн байгууллагын төв эсхүл салбар нь Өмнөговь аймагт бүртгэлтэй байх.
- 2. Үндэсний ханган нийлүүлэгч** гэж Монгол Улсад бүртгэлтэй, эзэмшлийн 50-иас дээш хувийг нь Монгол Улсын иргэн буюу иргэд эзэмшдэг компанийг хэлнэ.
- 3. 1-р ангиллын гадаадын ханган нийлүүлэгч:** Монгол Улсад бүртгэлтэй бөгөөд Монгол Улсад татвар төлдөг, компанийн төв нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, нийлүүлж байгаа бараа, үйлчилгээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нэмүү өртөг бий болгосон, нийт ажилтны 75-аас дээш хувь нь Монгол Улсын иргэн байх шаардлагыг хангасан нийлүүлэгчийг ойлгоно.
- 4. 2-р ангиллын гадаадын ханган нийлүүлэгч:** Монгол Улсад бүртгэлтэй бөгөөд Монгол улсад татвар төлдөг нийлүүлэгчийг ойлгоно.
- 5. 3-р ангиллын гадаадын ханган нийлүүлэгч:** Дээр дурдсан шаардлагуудыг хангаагүй ханган нийлүүлэгчийг ойлгоно.